



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 136

Мандалговь

Үндсэн хөрөнгө дуудлагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийн 6.2.3, 6.4 дэх хэсгийн 6.4.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Дэлгэрхангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 235,000.00 (хоёр зуун гучин таван мянга) төгрөгийн балансын үнэ, 29,375.10 (хорин есөн мянга гурван зуун далан таван төгрөг арван) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий нүүрсний агуулах, 1,054,600.00 (нэг сая тавин дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн балансын үнэ, 175,766.70 (нэг зуун далан таван мянга долоон зуун жаран зургаан төгрөг далан) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий цагаан агуулахыг тус тусакталж, дуудлага худалдаанд оруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгө худалдах доод үнийн хязгаарыг нүүрсний агуулахыг 300,000.00 (гурван зуун мянга) төгрөг, цагаан агуулахыг 500,000.00 (таван зуун мянга) төгрөгөөр тус тус тогтоон нээлттэй дуудлага худалдааг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар (С.Ууганбаяр)-т үүрэг болгосугай.

Гурав: Эд хөрөнгийг худалдсаны дараа хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Дэлгэрхангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Д.Будням)-д даалгасугай.

Дөрөв: Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0100333

Төрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 2018 оны 12 сарын 28-ний өдрийн
 № дугаар тогтоолын хавсралт

Дэлгэрхангай сумын Хүүхдийн цэцэрлэгийн акталж, даннаас хасах хөрөнгийн жагсаалт

№	Барилга, байгууламж ийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглалт анд орсон огноо	Ашиглалт ын нийт хугацаа	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжих нэгж	Биет хэмжээ					
1	Нүүрсний агуулах		12 м2	1	2004		235,000.00	29,375.10	205,624.90
2	Агуулах /цагаан/		24 м2	1	2008		1,054,600.00	175,766.70	878,833.30
НИЙТ ДҮН									
							1,289,600.00 (нэг сая хоёр зуун наян есөн мянга зургаан зуу)	205,141.80 (хоёр зуун таван мянга нэг зуун дөчин нэгэн төгрөг наян мөнгө)	1,084,458.20 (нэг сая наян дөрвөн мянга дөрвөн зуун тавин найман төгрөг хорин мөнгө)